



ҮНДЭСНИЙ ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН
ЧУУЛГЫН ЗАХИРАЛ Г.ЦОГГЭРЭЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/219
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үндэсний дуу бүжгийн чуулгын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдэд холбогдох хууль, УСНББОУС, түүнд Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА



ҮНДЭСНИЙ ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
С. Энхзаяа
Утас: 261663
Цахимхаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Н.Золзаяа
Утас:
Цахим хаяг: @audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Батсайхан
Утас:
Цахим хаяг: @audit.gov.mn

ТАБ-ын хаяг: ЗГ-ын IY байр
Бага тойруу 6 Улаанбаатар -46
Цахим хуудас:

“СМД” ХХК-ийн

Аудитын багийн ахлагч
Д.Гэндэнпэлжээ
Утас: 99172936,

Ахлах аудитор: А.Одонзул
Аудиторын туслах: Б. Мөнхцог,
Утас: 99175995

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Хүнсний 1-н ард 12/5 байр 7 тоот

Вэб хуудас: www.cmdaudit.mn

Имэйл хаяг: b_mts@yahoo.com

2016 оны 02 дугаар сарын 12

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйлажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Материаллаг байдлын түвшин
10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5-д заасан “Төрийн аудитын байгууллагасанхүүгийн тайланд аудит хийх чигүүргээ аудитын бусад байгуулла

гааргэрээний үндсэндээргүйцэтгүүлж болно.

Ийнхүүгүйцэтгэсэн аудитын тайлангийн чанарыг төрийн аудитын байгууллага баталгаажуулна.

Гэрээгээр аудит хийлгэх,

аудитын тайланг баталгаажуулах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална” гэж тус тус заасны дагуу Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын/ҮАГ-САГ/2016/24/СТА-ГАК-ТШЗ/төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 28-наас 2017 оны 2 дугаар сарын 08-ныг хүртэл хийхээр төлөвлөн аудитын багийн гишүүнээр “СМД Аудит” ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Д.Гэндэнпэлжээ, чанарын хяналтын менежер Б.Жаргал нар удирдан зохион байгуулж, “СМД Аудит” ХХК-ийн ахлах аудитор А.Одонзул, туслах аудитор Б.Мөнхцог нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга байгууллагын 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2016 оны 01 дүгээр сарын 25-нд “СМД Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“СМД Аудит” ХХК 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийг 2016 оны 10 дугаар сарын 10-наас 11 сарын 24-ны хооронд, завсрын аудитыг 2016 оны 10 дугаар сарын 10 -нд эхэлж, 2017 оны 01 дугаар сарын 25-нд дуусгасан ба завсрын аудитад 2016 оны эхний 9 сарын байдлаар санхүүгийн баримтуудыг хамруулсан. Харин жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 01 дүгээр сарын 25-наас 2016 оны 02 дугаар

сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2016 оны 02 дугаар сарын 25-нд Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга нь 2011 оны 12 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан “Төсвийн тухай хууль”, 1996 оны 05 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль, 2001 оны 12 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, 1994 оны 5 дугаар сарын 31-ны өдөр батлагдсан “Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын тухай” хууль, 2002 оны 06 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан “Төрийн албаны тухай”, 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдөр нэмэлт оруулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”, 1999 оны 5 дугаар сарын 14-ны өдөр батлагдсан “Хөдөлмөрийн тухай” хууль, 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Сангийн сайдын 290 тоот тушаал, 2006 оны 11 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Сангийн сайдын 388 тоот тушаал, 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан ССАЖ-ын сайдын А/465 тоот тушаал зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Байгууллагань "Монгол угсаатан, ястны утга соёлын өвийн сор дээжийг сурталчилах, судлах, сургах, хийгээд үйлчлүүлэгч, харилцагч түншүүдийнхээ эрэлт шаардлагад нийцсэн орчин цагийн болон дэлхийн сонгомол бүтээлийг урлах чадавх бүхий өндөр боловсролтой хамт олны бүрдлийг нэгтгэсэн мэргэжлийн урлагийн төв байх эрхэм зорилгыг тавин ажиллаж байна. Мөн түүнчлэн Монгол улсын төсвийн тухай хуулийн 4.1.34 дүгээр зүйлд “батлагдсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх” гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн захирагч байна” гэж заасны дагуу Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын захирал нь Төсвийн захирагчийн үүрийг гүйцэтгэж байна. Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын

эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансанд түүвэрчилсэн байдлаар аудитын 6 чиглэлээр 35 хяналтын горим, 1 нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан ССАЖ-ын сайдын 2013 оны А/465 тоот тушаалаар батлуулан 2014 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөн ажиллаж байна.

Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгайлан зааж өгсөн, Сангийн яамнаас батлагдан гарсан журмуудын өөрчлөлт тусгагдсан, санхүүгийн бүртгэлийн програмтай уялдсан байна.

Бид Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын ашиглагдаж байгаа компьютерын системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Интерактив ХХК-ын “Емералд” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна. Уг програм нь УСННБОУС болон Монгол улсын НББ-ийн стандартад нийцсэн тул Сангийн яамнаас ашиглах зөвшөөрөл авсан байна.

5. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар улсын төвлөрсөн төсвөөс 1,550,502.1 мянган төгрөгийн, бараа үйлчилгээний орлого 300,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөвлөсөн ч гүйцэтгэлээр улсын төвлөрсөн төсвөөс 1,495,102.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний орлогоос 203,404.6 мянган төгрөгийг олжээ. Үүнээс урсгал зардалд 1,850,502.1 мянган төгрөг батлагдсанаас 1,698,507.0 мянган төгрөг зарцуулж 151,995.1 мянган төгрөгөөрдутуу зарцуулсан байна. Тайлант онд нэмэлт санхүүжилтээр БСШУСЯ-ны төрийн нарийн бичгийн даргын А/121 тушаал, чуулганы уран сайхны зөвлөлийн 5 тоот тогтоолын дагууих зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 110 жилийн ойд зориулсан арга хэмжээтэй холбогдуулан “учиртай гурван толгой” аялгуут жүжигт дутагдаж байсан 10,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

7. Шилэн дансны мэдээлэл

Үндэсний дууд бүжгийн эрдмийн чуулга шилэн дансны дараах <https://shilendans.gov.mn/org/1147>сайтад байгууллагынхаа шилэн дансны цэсийг байршуулсан байна. Үүнд төсөв, гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл сар тутамд шинэчлэгдэн орсон байна.

8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу 4 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд 6 дансанд нийт 36 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

9. Материаллаг байдлын түвшин

Материаллаг байдлын суурийг төлөвлөлтийн шатанд нийт зардлын 2%-иар авах нь зохимжтой гэж үзсэн. Нийт зардлыг материаллаг байдлын суурь болгоход ашигласан үндэслэл нь тус байгууллага 2016 оны өөрийн нийт санхүүжилтийн 88%-ийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2%-иар үргэлжлүүлэн сонгосон бөгөөд энэ нь 33,970.1 мянган төгрөг болж байна.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт ажил гүйлгээний 75,0 хувийг эзэлж байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитын явцад төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансдын нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Байгууллагын 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлого 290,000.0 мянган төгрөг олохоор төлөвлөсөн ч гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 203,300.5 мянган төгрөг олж 86,699.5 мянган төгрөгөөр төсвийн орлогыг тасалдуулсан байна. Дараах хүснэгт №1-д 2016 оны санхүүгийн үр дүнгийн гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан шинжилгээ оруулав.

Хүснэгт1 Орлогын гүйцэтгэлийн шинжилгээ

/мянтөг/

ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ					
		2015 он	2016 он	Зөрүү	%
1	Билетийнборлуулалт	156,139.50	67,647.40	(88,492.10)	-57%
2	Ваучерийнтооцоо	116,915.00	122,102.15	5,187.15	4%
3	Захиалгаттоглолт	36,795.00	7,060.00	(29,735.00)	-81%
4	Гадууртоглолт	2,700.00		(2,700.00)	-100%
5	Гэрээнийтөлбөр		4,990.92	4,990.92	
6	Тайзтүрээс		1,500.00	1,500.00	
	НИЙТ ОРЛОГО	312,549.50	203,300.47	(109,249.04)	-35%

Дээрх хүснэгтэд ҮДБЭЧ-ийн 2016 болон 2015 оны орлогын эх үүсвэрийг ангилан харуулсан бөгөөд 2015 онд 4 төрлийн орлогын эх үүсвэртэй байсан бол 2016 онд 6 төрлийн орлогын эх үүсвэртэй болж шинээр 2 төрлийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлсэн сайшаалтай үзүүлэлт гарсан. Гэхдээ 2015 онтой харьцуулахад касс дээрх билет борлуулалт 88.492.1 мянган төгрөг буюу 57%-иар, албан байгууллагуудтай хийгддэг захиалгат тоглолтын орлого 29,735.0 мянган төгрөг буюу 81%-иар тус тус буурсан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Энэ алдаа байгууллагын удирдлагад мэдэгдсэн ба хойшид төсвийн аливаа нэг зарчмыг алдагдуулахгүй байхад анхаарч, төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахдаа төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйл “төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага”-ыг анхаарч ажиллах аа зөвшөөрсөн байна.

2. Тус байгууллага урлагийн хүмүүст ажлын хөлс 35,130.0 мянган төгрөгийг олгоходоо зөвхөн ХАОАТ суутгаж, НДШ-ийг тооцож аваагүй байна. Эдгээр хүмүүс нь тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай ижил төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа тул тогтмол бус орлого олгосон гэж үзэхэд хүндрэлтэй байна. Байгууллагын зүгээс үүнийг урлагийн байгууллагын тусгай шинжтэй зардал нь урлагийн зардал байдаг. Зохиол, хөгжмийн зохиол, найруулга, бүжиг дэглэлт, тайз, хувцасны зураг, эскиз гэх мэтийг уг бүтээгчээс нь худалдах худалдан авах гэрээний дагуу худалдан авч олгосон хөлснөөс зөвхөн ХАОАТ суутган авч төлбөрийг хийдэг. Учир нь уг зардлын байгууллагаас төлөх НДШ-ийн зардлыг төсөвт суугаагүй байдаг тул НДШ тооцож авдаггүй гэж тайлбар ирүүлсэн ба НБББББичигт энэ талаар тусгасан байгаа нь НД-ын хуулийн зарим зүйл заалттай зөрчилдөж байна.

Шийдвэрлэсэн: Энэ талаар Дээд шатны албанд НДЕГазар эсвэл Сангийн яамтай хэлэлцэж шийдвэрлүүлэх тухай дахин хүсэлт тавьж ажиллахаар болов.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

1. Төсвийн тухай хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд 6.4.8-д заасан “төсвийг зохистой

ҮДБЭЧ

удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хангахгүй байна. Дараах хүснэгт №2-т тус байгууллагатай холбоотой авлагын насжилтын судалгаа, тайлбарыг оруулж өгсөн болно.

Хүснэгт2 Авлагын насжилтын судалгаа

№	АВЛАГЫН НАСЖИЛТЫН СУДАЛГАА		
	2006 оноос өмнөх /Өмнөх нягтлан/	Мөнгөн дүн	Тайлбар
1	Адресс Гайстхаус ХХК-д	392.7	Үйл ажиллагаагаа зогсоогоод олдохоо больсон тул авлагаа авч чадахгүй болсон
2	Мэргэжлийн хяналтаас тавьсан акттай холбоотой	392.3	2003 онд тус байгууллагын хөгжимчид Франц улсад тоглолтоор явахдаа тэндээ үлдсэн бөгөөд байгууллагын хөгжмийн зэмсгийг буцааж олгоогүй байна. Дээрх хөгжмийн зэмсгийг яг хэн нь авч явсан талаарх нарийн мэдээлэлгүй бөгөөд мэргэжлийн хяналтаас акт тавьсан.
3	Хувь хүмүүстэй холбоотой өндөр насжилттай авлага	4,141.6	Баянзул, Даваасүрэн, Оюунсүрэн, Энхбат, Чулуунбаатар, Тамирмаа, Жамбал, Булигар, Орхонтужа, Алтанцэцэг нарын авлага гэж бүртгэсэн. Өмнөх нягтлан ажлаа хүлээлгэж өгөөгүй, баримтын бүрдэл дутуу. Авлагыг барагдуулахаар шүүхэд өгөх гэсэн боловч эзэн холбогдогчийн хаяг тодорхойгүй гэсэн шалтгаанаар шүүх нэхэмжлэл хүлээж аваагүй.
4	Эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага	179.6	Бусад авлага дээр бүртгэсэн.
	2006 оноос хойших /Н.Батсүрэн/	Мөнгөн дүн	Тайлбар
5	Б.Лхагвасүрэнтэй холбоотой “уран бүтээлийн авлага”	5,000.0	Уран бүтээл туурвиж өгөх гэрээний үүргээ биелүүлээгүй ба мэргэжлийн хяналтаас албан шаардлага хүргүүлсэн. Б.Лхагвасүрэн нь гэрээний дагуу уран бүтээл ээ туурвиж өгнө гэж амласан.
6	Ажилчидтай холбоотой авлага	257.5	Үйлчлэгч Дуламсүрэн тоос сорогч эвдсэн тул 206.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн бол Балжинням цалин бодохдоо алдаа гаргаж ХХОАТ дутуу суутгаж өгсөн тул 21.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Дээрх авлагын насжилтын судалгаа хийж үзэхэд нийт 5,170.5 мянган төгрөгийн авлага шийдэгдэх боломжгүй он удаан жил болж байна. Харин сүүлийн 2 жил түүнээс дотогш шинээр үүссэн уран бүтээлийн авлага, ажилчдаас авах авлага 5,257.5 мянган төгрөг байна.

Шийдвэрлэсэн: Энэ алдааг Ерөнхий нягтлан бодогч мэдсэн даруйдаа шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн гэдгээ мэдэгдсэн. Аудитын байгууллагын зүгээс сүүлийн 2 жил түүнээс дотогш үүссэн авлагыг барагдуулахад

анхаарч ажиллах талаар холбогдох хүмүүст зөвлөмж өгснийг хүлээн зөвшөөрсөн байна.

2. Төсвийн тухай хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд 6.4.8-д заасан “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хангахгүй байна. Хүснэгт 3-т байгууллагын өглөгтэй холбоотой судалгааг харуулав.

Хүснэгт 3 Өглөгийн судалгаа

№	ӨГЛӨГИЙН СУДАЛГАА		
	Ажилчидтай холбоотой өглөг	Мөнгөн дүн	Тайлбар
1	Ажилчидтай холбоотой өглөг	735.2	Э.Хишигбат томилолтын зардал өөрөөсөө зарцуулсан.
2	Байгууллагатай холбоотой өглөг	300.0	Фотокрафт ХХК-аар хийлгэсэн ажлын хөлс.
3	Цалингийн өглөг	50.0	Цалингийн зөрүү
	НИЙТ	1,085.2	

Дээрх 1,085.2 өглөгийг ажилчидтай холбоотой өглөгөөр бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Энэ алдааг дахин давтаж гаргахгүй байх талаар холбогдох хүмүүст зөвлөмж өгснийг хүлээн зөвшөөрсөн байна.

12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Материаллаг бус 11,513.2 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 133,342.73 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 86,699.5 мянган төгрөг нь орлогын гүйцэтгэл буурсантай, 35,130.0 мянган төгрөг нь НДШ хуулийн заалт болон дээд шатны байгууллагаас баталсан НББББичгийн зөрүүтэй заалттай холбоотой бөгөөд энэ нь байгууллагын удирдаж болох эрсдэлийн хир хэмжээнээс давсан тул материаллаг гэж үзэх боломжгүй болно. Харин материаллаг бус 11,513.2 мянган төгрөгийн авлага өр төлбөр, үүнээс богино хугацаатай 6,255.71 мянган төгрөгийн авлага өр төлбөртэй холбоотой алдааг дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгч ажиллаа.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2015 оны тайланд “СМД Аудит ХХК” аудит хийж нийт 7 зөвлөмж өгснөөс 6 хэрэгжүүлэн ажилласан байна. Тус байгууллага урлагийн хүмүүст ажлын хөлс 63,306.3 мянган төгрөгийг олгохдоо зөвхөн ХАОАТ суутгаж, НДШ-ийг тооцож аваагүй байна. Эдгээр хүмүүс нь тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай ижил төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа тул тогтмол бус орлого олгосон гэж үзэхэд хүндрэлтэй.

Байгууллагын зүгээс үүнийг урлагийн байгууллагын тусгай шинжтэй зардал нь урлагийн зардал байдаг. Зохиол, хөгжмийн зохиол, найруулга, бүжиг дэглэлт, тайз, хувцасны зураг, эскиз гэх мэтийг уг бүтээгчээс нь худалдах худалдан авах гэрээний дагуу худалдан авч олгосон хөлснөөс зөвхөн ХАОАТ суутган авч төлбөрийг хийдэг. Учир нь уг зардлын байгууллагаас төлөх НДШ-ийн зардлыг төсөвт суугаагүй байдаг тул НДШ тооцож авдаггүй гэж тайлбар ирүүлсэн ба НБББББичигт энэ талаар тусгасан байгаа нь НД-ын хуулийн зарим зүйл заалттай зөрчилдөж байна. Энэ талаар Дээд шатны албанд НДЕГазар эсвэл Сангийн яамтай хэлэлцэж шийдвэрлүүлэх тухай хүсэлт тавьж ажиллах зөвлөмж өгсний дагуу хүсэлтийг дээд шатны байгууллагад хүргүүлсэн боловч тодорхой шийдэлд хүрч чадаагүй хэвээр байна.

17. Зөрчилгүй-санал дүгнэлт

Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ҮДБЭЧ



ҮНДЭСНИЙ ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГА

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол № 2

Асуудал 1

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Аудитынгазар нь аудитбүрийнтөгсгөлдаудитаарилрүүлсэнзүйлсийгнэгтгэсэнменежментийнзахидлыгүйлчлүүлэгч идзориулжбэлтгэдэгбөгөөдтүүндхяналтынсулталбуюугоримыгөөрчлөхзамаархяналтыгсайжруул ахзөвлөмжийгтусгадагбилээ.

ЭнэхүүменежментийнзахидлынагуулгаАудитынолонулсынстандартболонатаудитынгоримо осургангарсанболно.

Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний ойлголтыг тусгасан. Эдгээр зөвлөмжийг та бидний хамт янажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитыг хэрэгжүүлэх явцад дараах горимуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын системийг судлах
- Санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын үйл ажиллагааг тодорхойлж, эрсдэлийг үнэлэх
- Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, журналаас ажил гүйлгээг хөөн шалгаж үлдэгдлийг тохируулах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга байгууллагын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

Байгууллагын НБББББичиг дэх зарим нэгэн заалт НД-ын хуулийн зарим нэгэн заалттай зөрчилдөж байгааг шийдвэрлэвэл зохих.

Асуудал – 1

Тэргүүлэх ач холбогдол №2

Ажиглалт:

- Тус байгууллага урлагийн хүмүүст ажлын хөлс гэж 35,130.0 мянган төгрөгийг олгохдоо зөвхөн ХАОАТ суутгаж аваад НДШ тооцож аваагүй байна. Эдгээр хүмүүс нь тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай ижил төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа тул тогтмол бус орлого олгосон гэж үзэхэд хүндрэлтэй байна. Байгууллагын зүгээс үүнийг урлагийн байгууллагын тусгай шинжтэй зардал нь урлагийн зардал байдаг. Зохиол, хөгжмийн зохиол, найруулга, бүжиг дэглэлт, тайз, хувцасны зураг, эскиз гэх мэтийг уг бүтээгчээс нь худалдах худалдан авах гэрээний дагуу худалдан авч олгосон хөлснөөс зөвхөн ХАОАТ суутган авч төлбөрийг хийдэг. Учир нь уг зардлын байгууллагаас төлөх НДШ-ийн зардлыг төсөвт суугаагүй байдаг тул НДШ тооцож авдаггүй гэж тайлбар ирүүлсэн ба НБББББичигт энэ талаар тусгасан байгаа нь НД-ын хуулийн зарим зүйл заалттай зөрчилдөж байна

Эрсдэл:

- Нийгмийн даатгалын шимтгэлийг холбогдох хууль, заавар журмын дагуу тооцоогүй байх;

Зөвлөмж:

Энэ талаар Дээд шатны байгууллагад дараах хүсэлтийг гаргаж ажиллах. Үүнд

- Нийгмийн даатгалын ерөнхий газартай урлагийн зардлын нийгмийн даатгалыг чөлөөлөх талаар хэлэлцэж шийдвэрт хүрэхэсвэл;
- Сангийн яамтай хэлэлцэж тус урлагийн хүмүүст олгож буй ажлын хөлсний байгууллагаас төлөх НДШ-ийг төсөвт суулгуулах талаар хэлэлцэж шийдвэрт хүрэх.

Үйлчлүүлэгчийн хариу:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн ба өгсөн зөвлөмжийн дагуу Дээд шатны байгууллагад хүсэлт гаргахаар болсон.

АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагыннэр: Үндэсний дуу бүжгийн
эрдмийн чуулга

Тайлантогноо: 2016.12.31

дд	Сорилхи йсэнданс нынэр	Аудитаарилэрсэнасуудал	Санхүүгийнтай ландүзүүлэхнө лөө (материаллаг,м атериаллагбус)	Аудиторынсан ал (Бүртгэлийнби чилт, тооцоолол)	Тухайнбайгууллагынудирдлагынсанал (Бүртгэлийнбичилт, тооцоолол)	Уулзалтыннүрдүнгийнбаталгаажуулалт
1	Орлого	Байгууллагын 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлого 290,000.0 мянган төгрөг олохоор төлөвлөсөн ч гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 203,300.5 мянган төгрөг олж 86,699.5 мянган төгрөгөөр төсвийн орлогыг тасалдуулсан байна. ҮДБЭЧ-ийн2016 оны орлогын эх үүсвэрийг ангиллыг өмнөх онтой харуулсан бөгөөд 2015 онд 4 төрлийн орлогын эх үүсвэртэй байсан бол 2016 онд 6 төрлийн орлогын эх үүсвэртэй болж шинээр 2 төрлийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлсэн сайшаалтай үзүүлэлт гарсан. Гэхдээ 2015 онтой харьцуулахад касс дээрх билет борлуулалт 88.492.1 мянган төгрөг буюу 57%-иар, албан байгууллагуудтай хийгддэг захиалгат тоглолтын орлого 29,735.0 мянган төгрөг буюу 81%-иар тус тус буурсан байна.	Материаллаг	Энэ нь төсвийн тухай хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг хангахгүй байна.	Зөвшөөрч байна. Гэхдээ 2016 оны 7 дугаар сард АСЕМ-тай холбоотой маш олон ажил хийгдсэн ба энэ үеэр хийгддэг тоглолтууд хийгдээгүй болно. Мөн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалж үзэгчдийн тоо буурсан.	Энэ алдаа байгууллагын удирдлагад мэдэгдсэн ба хойшид төсвийн аливаа нэг зарчмыг алдагдуулахгүй байхад анхаарч, төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахдаа төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйл “төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага”-ыг анхаарч ажиллах аа зөвшөөрсөн байна.
2	Зардал	Тус байгууллага урлагийн хүмүүст ажлын хөлс гэж 35,130.0 мянган төгрөгийг олгохдоо зөвхөн ХАОАТ суутгаж аваад НДШ тооцож аваагүй байна. Эдгээр хүмүүс нь тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай ижил төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа тул тогтмол бус орлого олгосон гэж үзэхэд хүндрэлтэй байна.	Материаллаг	Хуульдүрэмзөр чсөн	Зөвшөөрчбайна.Урлагийн байгууллагын тусгай шинжтэй зардал нь урлагийн зардал байдаг. Зохиол, хөгжмийн зохиол, найруулга, бүжиг дэглэлт, тайз, хувцасны зураг, эскиз гэх мэтийг уг бүтээгчээс нь худалдах худалдан авах гэрээний дагуу худалдан авч олгосон хөлснөөс зөвхөн ХАОАТ суутган авч төлбөрийг хийдэг. Учир нь уг зардлын байгууллагаас төлөх НДШ-ийн зардлыг төсөвт суугаагүй байдаг тул НДШ тооцож авдаггүй.	Энэ талаар Дээд шатны байгууллагад дараах хүсэлтийг гаргаж ажиллах. Үүнд ➤ Нийгмийн даатгалын ерөнхий газартай урлагийн зардлын нийгмийн даатгалыг чөлөөлөх талаар хэлэлцэж шийдвэрт хүрэхэсвэл; ➤ Сангийн яамтай хэлэлцэж тус урлагийн хүмүүст олгож буй ажлын хөлсний байгууллагаас төлөх НДШ-ийг төсөвт суулгуулах талаар хэлэлцэж шийдвэрт хүрэх
3	Авлага ба өглөг	Авлагын насжилтын судалгаа хийж үзэхэд нийт 5,170.5 мянган төгрөгийнавлага шийдэгдэх боломжгүй он удаан жил болж байна. Харин	Материаллаг бус	Төсвийнтухайх уулийн 5.1.3-т заасансанхүү,	Өндөр насжилттай авлагыг барагдуулах талаар ерөнхий нягтлан бодогч мэдсэн даруйдаа шаардлагатай	Аудитын байгууллагын зүгээс сүүлийн 2 жил түүнээс дотогш үүссэн авлагыг барагдуулахад анхаарч ажиллах талаар

ҮДБЭЧ

сүүлийн 2 жил түүнээс дотогш шинээр үүссэн уран бүтээлийн авлага, ажилчдаас авах авлага 5,257.5 мянган төгрөг байна.1,085.2 өглөгийг ажилчидтай холбоотой өглөг үүсгэсэн.

төсвийнзохист ойудирдлагыгх эрэгжүүлэхзар чмыгхэрэгжүүлэххүрээнд 6.4.8-д заасан “төсвийгзохист ойудирдажавлага, өртөлбөрүүсгэхгүйбайх” заалтыгхангахгүйбайна.

арга хэмжээг авч хэрэгжүүлсэн гэдгээ мэдэгдсэн.

холбогдох хүмүүст зөвлөмж өгснийг хүлээн зөвшөөрсөн байна. Мөн өглөгтэй холбоотой зарим нэг алдааг дахин гаргахгүй байх талаар холбогдох хүмүүст зөвлөмж өгснийг хүлээн зөвшөөрсөн байна.

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>774,367,531.24</u>	<u>798,021,790.22</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	10,510,745.32	10,428,019.27
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	340,254.16	257,528.11
335	Бусад авлага	10,170,491.16	10,170,491.16
3351	Байгууллагаас авах авлага	64,261.06	64,261.06
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,106,230.10	10,106,230.10
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	763,856,785.92	787,593,770.95
351	Түүхий эд материал	127,673,556.06	130,348,250.09
35110	Тусгай зориулалттай материал	127,673,556.06	130,348,250.09
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,241,858.22	2,450,160.00
354	Хангамжийн материал	631,941,371.64	654,795,360.86
35420	Аж ахуйн материал	631,941,371.64	654,795,360.86
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>393,780,376.24</u>	<u>314,101,390.90</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	393,780,376.24	314,101,390.90
392	Биет хөрөнгө	393,780,376.24	314,101,390.90
39203	Авто-тээврийн хэрэгсэл	211,100,000.00	213,347,827.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	(73,359,286.17)	(108,608,460.69)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	257,581,050.79	269,149,040.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	(126,012,429.41)	(161,829,127.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	197,809,869.51	200,809,869.51
39208	Хуримтлагдсан элэгдэл	(128,613,370.28)	(142,705,415.04)
39214	Бусад үндсэн хөрөнгө	470,441,668.49	472,901,668.49
39215	Хуримтлагдсан элэгдэл	(415,167,126.69)	(428,964,012.15)
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	1,488,750.00	1,488,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,488,750.00)	(1,488,750.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,168,147,907.48</u>	<u>1,112,123,181.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,085,214.28</u>	<u>1,085,214.28</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,085,214.28	1,085,214.28
411	Богино хугацаат үнэт цаас	-	-
412	Богино хугацаат зээлийн өглөг	-	-
413	Өглөг	1,085,214.28	1,085,214.28
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,085,214.28	1,085,214.28
4136	Бусад өглөг	-	-
414	Урьдчилж орсон орлого	-	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
421	Урт хугацаат үнэт цаас	-	-
422	Урт хугацаат зээл	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,167,062,693.20</u>	<u>1,111,037,966.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,167,062,693.20	1,111,037,966.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	601,000,655.43	601,000,655.43

51101	Өмч: - төрийн	601,000,655.43	601,000,655.43
512	Хуримтлагдсан үр дүн	539,958,240.77	483,933,514.41
51210	Өмнөх үеийн үр дүн	41,001,748.32	(56,024,726.36)
51220	Тайлант үеийн үр дүн	498,956,492.45	539,958,240.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,103,797.00	26,103,797.00
6	ОР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,168,147,907.48</u>	<u>1,112,123,181.12</u>

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,908,413,637.78	1,716,050,392.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	392,617,009.18	205,548,292.25
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	312,549,500.00	203,300,465.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,520,675.38	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	78,546,833.80	2,247,827.25
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,515,796,628.60	1,510,502,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,348,206,900.00	1,500,502,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,348,206,900.00	1,500,502,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	167,589,728.60	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,699,700.00	10,000,000.00
131106	Төсвийн урамшуулал	6,890,028.60	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,867,411,889.46	1,772,075,118.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,867,411,889.46	1,772,075,118.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,792,926,970.11	1,760,054,767.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,324,377,894.58	1,379,514,557.37
210101	Үндсэн цалин	1,206,237,994.58	1,262,424,957.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	118,139,900.00	117,089,600.00
2102	Ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,054,472.54	151,830,262.38
210201	Тэтгэврийн даатгал	93,009,151.24	96,706,895.40
210202	Тэтгэмжийн даатгал	10,630,901.30	11,049,193.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,288,527.83	13,811,492.71
210204	Ажилгүйдлийн даатгал	2,657,625.11	2,762,298.93
210205	Эрүүд мэндийн даатгал	26,468,267.06	27,500,381.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	25,284,672.84	10,535,404.78
210401	Бичиг хэрэг	1,190,660.00	1,477,769.00
210402	Тээвэр, шатахуун	4,798,425.00	2,192,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,203,689.53	1,562,000.00
210404	Ном, хэвтэл	293,799.60	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,798,098.71	5,303,635.78
2105	Нормативт зардал	-	422,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	-	422,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,543,835.00	4,173,070.00
210604	Урсгал засвар	1,543,835.00	4,173,070.00
2107	Томилдолт, зочны зардал	536,200.00	950,000.00
210702	Дотоод албан томилдолт	200,000.00	950,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	336,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	179,679,210.56	110,134,983.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	179,679,210.56	110,134,983.19
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,450,684.59	102,494,489.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,539,687.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	115,450,684.59	98,954,802.59
211	ХҮҮ	-	-
212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,484,919.35	12,020,351.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,162,610.00	6,620,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,162,610.00	6,620,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	48,322,309.35	5,399,651.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,322,309.35	5,399,651.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	41,001,748.32	(56,024,726.36)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,001,748.32	(56,024,726.36)

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,829,946,128.60	1,743,215,334.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	314,149,500.00	214,351,450.96
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	312,549,500.00	203,300,465.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,600,000.00	11,050,985.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,515,796,628.60	1,528,863,884.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,348,206,900.00	1,500,502,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,348,206,900.00	1,500,502,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	167,589,728.60	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,699,700.00	10,000,000.00
131106	Төсвийн урамшуулал	6,890,028.60	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	18,361,784.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		18,361,784.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,803,832,528.60	1,726,187,344.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,803,832,528.60	1,726,187,344.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,729,894,259.25	1,714,166,993.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,325,091,968.61	1,398,007,116.28
210101	Үндсэн цалин	1,202,129,068.61	1,280,917,516.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	118,139,900.00	117,089,600.00
210104	Урамшуулал	4,823,000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,426,199.51	151,720,862.38
210201	Тэтгэврийн даатгал	92,380,878.21	96,706,895.40
210202	Тэтгэмжийн даатгал	10,630,901.30	11,049,193.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,288,527.83	13,811,492.71
210204	Ажилгүйдлийн даатгал	2,657,625.11	2,762,298.93
210205	Эрүүл мэндийн даатгал	26,468,267.06	27,390,981.57
2104	Хангамж, бараа материалын зардал	8,999,967.13	4,866,720.00
210401	Бичиг хэрэг	1,071,350.00	921,830.00
210402	Тээвэр, шатахуун	3,983,425.00	582,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,907,812.53	1,562,000.00
210404	Ном, хэвлэл	293,799.60	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,743,580.00	1,800,890.00
2105	Нормативт зардал	340,000.00	648,860.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	340,000.00	648,860.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,326,195.00	585,800.00
210604	Урсгал засвар	1,326,195.00	585,800.00
2107	Томилолт, зочны зардал	536,200.00	950,000.00
210701	Гадаад албан томилолт	336,200.00	
210702	Дотоод албан томилолт	200,000.00	950,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	247,258,920.00	146,440,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	244,272,500.00	143,312,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	358,420.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	628,000.00	1,128,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	914,809.00	10,946,885.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	914,809.00	10,946,885.00
211	ХҮҮ	-	-
212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,938,269.35	12,020,351.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,615,960.00	6,620,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,296,060.00	6,620,700.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,319,900.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	48,322,309.35	5,399,651.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,322,309.35	5,399,651.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>26,113,600.00</u>	<u>17,027,990.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	26,113,600.00	17,027,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,113,600.00	17,027,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	26,113,600.00	17,027,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,113,600.00	17,027,990.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(26,113,600.00)</u>	<u>(17,027,990.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,000,655.43	26,103,797.00	493,956,492.45	1,121,060,944.88
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			5,000,000.00	5,000,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	601,000,655.43	26,103,797.00	498,956,492.45	1,126,060,944.88
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			41,001,748.32	41,001,748.32
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,000,655.43	26,103,797.00	539,958,240.77	1,167,062,693.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	601,000,655.43	26,103,797.00	539,958,240.77	1,167,062,693.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-56,024,726.36	-56,024,726.36
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,000,655.43	26,103,797.00	483,933,514.41	1,111,037,966.84

АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,850,502,100.00	1,698,507,014.66	151,995,085.34	0.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,850,502,100.00	1,698,507,014.66	151,995,085.34	0.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,843,881,400.00	1,691,886,314.66	151,995,085.34	0.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,381,542,400.00	1,379,645,332.28	1,897,067.72	1.00
210101	Үндсэн цалин	1,263,402,500.00	1,262,555,732.28	846,767.72	1.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	118,139,900.00	117,089,600.00	1,050,300.00	99.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,863,800.00	151,720,862.38	142,937.62	99.91
210201	Тэтгэврийн даатгал	96,657,500.00	96,706,895.40	(49,395.40)	100.05
210202	Тэтгэмжийн даатгал	11,046,500.00	11,049,193.77	(2,693.77)	100.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,808,200.00	13,811,492.71	(3,292.71)	100.02
210204	Ажилгүйдлийн даатгал	2,761,600.00	2,762,298.93	(698.93)	100.03
210205	Эрүүл мэндийн даатгал	27,590,000.00	27,390,981.57	199,018.43	99.28
2104	Хангамж, бараа материалын зардал	4,870,300.00	4,866,720.00	3,580.00	99.93
210401	Бичиг хэрэг	765,500.00	921,830.00	(156,330.00)	120.42
210402	Тээвэр, шатахуун	873,500.00	582,000.00	291,500.00	66.63
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,352,000.00	1,562,000.00	(210,000.00)	115.53
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,879,300.00	1,800,890.00	78,410.00	95.83
2105	Нормативт зардал	664,700.00	648,860.00	15,840.00	97.62
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	664,700.00	648,860.00	15,840.00	97.62
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	855,600.00	585,800.00	269,800.00	68.47
210604	Урсгал засвар	855,600.00	585,800.00	269,800.00	68.47
2107	Томилолт, зочны зардал	956,600.00	950,000.00	6,600.00	99.31
210702	Дотоод албан томилолт	956,600.00	950,000.00	6,600.00	99.31
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй	303,128,000.00	153,468,740.00	149,659,260.00	50.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	300,000,000.00	150,340,740.00	149,659,260.00	50.11
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,128,000.00	1,128,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,620,700.00	6,620,700.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,620,700.00	6,620,700.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,620,700.00	6,620,700.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,850,502,100.00	1,698,507,014.66	151,995,085.34	91.79
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,550,502,100.00	1,495,102,448.70	55,399,651.30	96.43
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,550,502,100.00	1,495,102,448.70	55,399,651.30	96.43
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	300,000,000.00	203,404,565.96	96,595,434.04	67.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	290,000,000.00	203,300,465.00	86,699,535.00	70.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	104,100.96	9,895,899.04	1.04
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	189.00	189.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	167.00	167.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	21.00	21.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	189.00	189.00	-	100.00
650006	Соёл урлагийн салбарын терийн үйлчилгээний албан хаагч (ТҮСҮ)	170.00	189.00	(19.00)	111.18
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19.00	-	19.00	-